

3-ХҮАХО-1

ХҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ОСЛЫН БҮРТГЭЛИЙН МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Маягт 3-ХҮАХО-1-ийг хүний үйл ажиллагаатай холбоотой ослын талаарх мэдээллийг бүртгэхэд ашиглана. Тухайн ослын дуудлагаар очсон аврах анги, салбар, бүлэг өөрийн хүчээр ослын хор уршгийг арилгасан бол энэхүү маягыг бүрэн гүйцэд бөглөж мэдээллийн санд бүртгэнэ.

Хэрэв тухайн ослын хор уршиг дуудлагаар болон нэмэлтээр очсон аврах анги, салбар, бүлгийн хүчин чадлаас давж орон нутгийн төрийн захиргааны байгууллага, Засаг дарга эсхүл тухайн шатны онцгой комисс, холбогдох салбарын яамнаас шуурхай бүлэг, ажлын хэсэг томилсон бол III, IV бүлгийг томилогдсон бүлэг, ажлын хэсэг хийж гүйцэтгэнэ.

БҮЛЭГ I ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Осол тохиолдсон газрын байршил

1.1. Аймаг, нийслэл: Тухайн осол тохиолдсон аймаг, нийслэлийн нэрийг гаргацтай бичиж, кодыг нөхнө.

"аймаг, нийслэлийн код"-ийг Монгол Улсын бүсчлэлийн кодын дагуу нөхнө.

Тухайлбал, Архангай аймаг 65000, Хөвсгөл аймаг 67000

Хамарсан тоо Тухайн осол болон ослын хор уршиг хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан тоог бичнэ.

1.2. Сум, дүүрэг: Тухайн осол тохиолдсон сум, дүүргийн нэрийг гаргацтай бичиж, холбогдох кодыг нөхнө.

"сум, дүүргийн код"-ийг Монгол Улсын бүсчлэлийн кодын дагуу нөхнө.

Тухайлбал, Архангай аймгийн Хашаат сум 65010, Хөвсгөл аймгийн Мөрөн сум 67120

Хамарсан тоо Тухайн осол болон ослын хор уршиг хэдэн сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан тоог бичнэ

1.3. Баг, хороо: Тухайн осол тохиолдсон баг, хорооны нэрийг гаргацтай бичнэ.

Хамарсан тоо Тухайн осол болон ослын хор уршиг хэдэн баг, хорооны нутаг дэвсгэрийг хамарсан тоог бичнэ

1.4. Хаяг: Тухайн осол тохиолдсон газрын хаягийг гаргацтай, тодорхой бичнэ.

1.5. Солбицол: Уртраг, өргөргийг оруулахдаа градус, минут, секундээр илэрхийлэн бичнэ.

1.6. Гурван үгт хаяг: Ухаалаг гар утасны what3words программыг ашиглан авсан байршлын 3 үгийг бичнэ. Жишээлбэл: жаалхүү.уриалах.аврагч гэх мэт. Координат нь тодорхой бол бичихгүй байж болно.

1.7. Мэдээлэл хүлээж авсан огноог он, сар, өдөр, цаг, минутаар бичнэ. Цагийг 01.00-24.00 хэлбэрээр бичнэ.

1.8. Эх сурвалж: ослын мэдээллийг ирүүлсэн эх сурвалжийг сонгоно.

1.9. Мэдээлэл өгсөн хүн: ослын дуудлага мэдээллийг ирүүлсэн хүний утасны дугаар, нэрийг бичиж хүйсийг тэмдэглэнэ.

1.10. Мэдээлэл хүлээн авсан сувгийг тэмдэглэнэ.

1.11. Мэдээллийн товч утга: Хүлээн авсан мэдээллийн товч утгыг бичнэ.

1.12. Ослын төрлийг үйлдвэрлэлийн, үйлдвэрлэлийн бус, тээврийн хэрэгслийн осол гэсэн төрлөөр ялган харгалзах дугаарыг дугуйлна.

- "Үйлдвэрлэлийн осол" гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг хэлнэ.

- "Тэсэрч дэлбэрэх бодистой холбогдолтой осол" гэж гадны хүчин зүйл, технологийн горим болон аюулгүй ажиллагаа зөрчих, хадгалалт, хамгаалалт, санамсар болгоомжгүйгээс хүний амь нас, эрүүл мэнд, мал амьтан, эд хөрөнгө, байгаль орчин, нийгэмд хохирол учруулахыг хэлнэ.

- "Тэсэрч дэлбэрэх бодис" гэж тэсэлгээний хэрэгсэл гадны үйлчлэлийн нөлөөгөөр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, өндөр даралт үүсгэн дулаан ялгаруулах химийн нэгдэл буюу механик хольцыг хэлнэ.

-“Тэсэлгээний хэрэгсэл” гэж тэсэрч дэлбэрэх бодисын тэсрэлтийг үүсгэх зориулалттай цэнэг агуулсан өдөөгч хэрэгслийг хэлнэ.

-“Тэсрээгүй сум, галт хэрэгсэл” гэж тэсрээгүй боловч цаашид тэсрэх эрсдэл бүхий гал хэрэгслийг хэлнэ. Мина, гранат, их бууны болон танкны сум, онгоцны бөмбөг, бууны сум гэх мэт.

-“Пиротехникийн хэрэгсэл” гэж хурц гэрэл гэгээ цацруулдаг буюу чанга дуу чимээ үүсгэдэг баяр ёслол, үзвэр, цэнгээний зориулалтаар ашиглагдах хэрэгслийг хэлнэ.

-“Нүүрсний давхаргын метан хий” гэж нүүрсжих явцад нүүрсэнд хуримтлагдсан хийг;

-“Сум, галт хэрэгсэлтэй холбогдолтой осол” гэж гадны хүчин зүйл, аюулгүй ажиллагаа зөрчих, санамсар болгоомжгүйгээс хүний амь нас, эрүүл мэнд, мал амьтан, эд хөрөнгө, байгаль орчин, нийгэмд хохирол учруулахыг хэлнэ.

-“Цацрагийн осол” гэж цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх, хадгалах, ашиглах, булшлах явцад технологийн горим зөрчигдөж гэмтэл гарах, орчинд их хэмжээгээр тархах зэргээс шалтгаалан хүн, мал, амьтан, хүрээлэн буй орчинд аюул учруулах тохиолдлыг хэлнэ.

-“Химийн осол” гэж химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах үйл ажиллагааны горим зөрчигдөх, технологийн явцын эвдрэл, санамсар болгоомжгүй байдал, байгалийн аюулт үзэгдэл зэргээс химийн хорт болон аюултай бодис алдагдаж, хүн, мал, амьтан, хүрээлэн буй орчинд аюул учруулах тохиолдлыг хэлнэ.

- “Тээврийн хэрэгслийн осол” гэж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг хэлнэ.

Тээврийн хэрэгслийн ослын хувьд Онцгой байдлын байгууллага дуудлагаар ажилласан тохиолдолд энэхүү бүртгэлийг хөтөлнө.

БАТАЛГААЖУУЛАЛТ - Осол гарсан тухай дуудлагыг хүлээн авч бүртгэсэн шуурхай удирдлагын оператор харьяа анги, салбар, цол, нэрийг гаргацтай бичиж гарын үсгээр баталгаажуулан тус тохиолдол дээр ажиллах салаа, бүлгийн дарга, захирагчид хүлээлгэн өгнө.

БҮЛЭГ II НӨХЦӨЛ БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2. Хугацаа

Осол болсон, дуудлага хүлээн авсан, ослын голомтод очсон, аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг эхлүүлсэн, дууссан он, сар, өдөр, цаг, минутыг дарааллын дагуу бүрэн гүйцэд, гаргацтай нөхөж бичнэ. Цагийг 01.00-24.00 хэлбэрээр бичнэ.

Үргэлжилж байгаа: Тухайн аюулт үзэгдэл, осол 48 цагаас дээш хугацаагаар үргэлжилж байгаа бол харгалзах хугацааг сонгоно.

3. Ослын нөхцөл байдлын зургийг гамшгийн орон зайн мэдээллийн системд зураглах бөгөөд нөхцөл байдлын зургийг хавсаргаагүй бол тайлбарыг бичнэ. Нөхцөл байдлын зурагт хүснэгт 2, 8, 10-д заасан мэдээллийг тэмдэглэнэ. Нөхцөл байдлын зураг нь 21x29 /A4/ хэмжээнээс багагүй байна.

4. Ослын шалтгаан

Ослын голомтод ажилласан салбар, бүлэг осол болсон шалтгааныг урьдчилсан байдлаар буюу эхний багананд дугуйлна. Ослын шалтгаан холбогдох мэргэжлийн байгууллагаар тогтоогдсоны дараа батлагдсан багананд нөхөж дугуйлна.

1 дүгээр мөрөнд Хууль бус үйл ажиллагаанаас гарсан шалтгааныг нөхнө.

2 дугаар мөрөнд Техник технологийн горим зөрчигдсөнөөс гарсан шалтгааныг нөхнө.

3 дугаар мөрөнд Аюулгүй ажиллагааны горим зөрчигдсөнөөс гарсан шалтгааныг нөхнө.

4 дүгээр мөрөнд Зориуд санаатайгаар осол гаргасан шалтгааныг нөхнө.

5 дугаар мөрөнд Хүний санамсар болгоомжгүйгээс шалтгаалсан гарсан шалтгааныг бүртгэнэ.

6 дугаар мөрөнд ослын шалтгааныг тогтоох боломжгүй, шалтгаан нь эхний болон шинжилгээгээр батлагдан тогтоогүй бол шалтгаан тогтоодоогүй гэж үзэн бүртгэнэ.

7 дугаар мөрөнд 1-6 дугаар мөрөнд тавигдсан шалтгаанаас бусад (сураггүй болсон, гэх мэт) шалтгааныг хамруулан бүртгэнэ.

5. Орчны нөхцөл байдал

Ослын тухайн цагийн байдалд үнэлгээ өгч, эрэн хайх, аврах нэгжийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг зохион байгуулах шийдвэр гаргах зорилгоор ослын үед орчны нөхцөл, бодит байдлыг тодорхойлох үзүүлэлтүүдийг бүртгэнэ.

1 дүгээр мөрөнд ослын тохиолдол гарсан байршлын агаарын температурыг хэмжиж нөхнө.

2 дугаар мөрөнд объект, барилга, байгууламж дотор ослын тохиолдол гарсан тохиолдолд тухайн байршлын агаарын температурыг хэмжиж нөхнө.

3 дугаар мөрөнд Осол гарсан байршлын агаарын бохирдлыг зарим тохиолдолд хэмжиж нөхнө. Жишээлбэл, уул уурхайн осол, цацраг, химийн хорт болон аюултай бодисын осол, угаарын хийн осол, төв цэвэрлэх байгууламжийн осол гэх мэт.

–“агаарын бохирдол” гэж хүрээлэн байгаа агаарт шууд хаягдсан, эсхүл физик, химийн урвалын дүнд шинээр үүсэж бий болсон бохирдуулах бодисын агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхийг;

4 дүгээр мөрөнд ослын тохиолдол гарсан байршлын салхины хурдыг нөхнө. Салхины хурдыг “м/с”-ээр хэмжинэ. Салхины хурдыг ус, цаг уур, орчны шинжилгээний байгууллагаас зарласан тухайн өдрийн албан ёсны мэдээгээр авна.

5 дугаар мөрөнд ослын тохиолдол гарсан байршлын салхины чиглэлийг нөхнө. Салхины чиглэлийг ус, цаг уур, орчны шинжилгээний байгууллагаас зарласан тухайн өдрийн албан мэдээ эсвэл тухайн үед хийсэн шууд хэмжилтийн үр дүнгээр авна.

6 дугаар мөрөнд ослын тохиолдол гарсан байршлын салхины чиглэлийн өөрчлөлтийн тоог нөхнө. Салхины чиглэлд гарсан өөрчлөлтийг тухайн үед гарсан өөрчлөлтийн давтамжийн тоогоор бүртгэнэ.

7 дугаар мөрөнд ослын тохиолдол гарсан байршлын тухайн үеийн чийгшлийн хэмжээг нөхнө. Чийгшлийн хэмжээг “мм”-ээр хэмжин нөхнө. Чийгшлийг тухайн үед хийсэн шууд хэмжилтийн үр дүнгээр авна.

8 дугаар мөрөнд ослын тохиолдол гарсан байршлын тухайн үеийн үзэгдэх орчны байдлыг сайн, дунд, муу гэсэн утгаар илэрхийлэн нөхнө.

9 дүгээр мөрөнд ослын тохиолдол гарсан байршлыг объект, барилга, байгууламжийн гадна эсвэл дотор гэсэн сонголтоос сонгож нөхнө.

10 дугаар мөрөнд объект, барилга, байгууламж дотор ослын тохиолдол гарсан тохиолдолд объектын материал, хийцийг нөхнө.

11 дүгээр мөрөнд ослын тохиолдол гарсан объектын дотор байгаа бараа, материалыг нэрийг бичнэ. Тухайлбал, хүнсний бараа, цахилгаан хэрэгсэл, химийн бодис гэх мэт

12 дугаар мөрөнд ослын тохиолдолсон объект, барилга, байгууламж агааржуулалттай эсэхийг нөхнө.

13 дугаар мөрөнд ослын тохиолдол гарсан объект, барилга, байгууламж усан хангамжтай эсэхийг нөхнө.

6. Тэсэрсэн/илэрсэн бодис материал

Тэсэрсэн болон илэрсэн бодис, хий, сум, галт хэрэгслийн төрөл, нэр, тоо ширхэг, хэмжээ болон алдагдсан орчинг нөхнө.

Цацраг идэвхт бодис, химийн аюултай болон хорт бодис нь агаар, ус, хөрс алинд алдагдсан эсэхийг \checkmark гэж тэмдэглэнэ. 2 болон түүнээс дээш тэмдэглэгээ хийж болно.

7. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ашигласан техник, багаж хэрэгслийн талаарх илтгэх хуудсыг хавсаргана.

8. Ажилласан хүч хэрэгсэл

Аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилласан гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дуррын хэсэг, нутгийн захиргааны байгууллага, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, дайчлагдан ажилласан болон олон улсын байгууллага, бусад байгууллага, хувь хүнийг хамруулна.

1-5 дугаар мөрөнд ослын хор уршгийг арилгахаар ажилласан анги, салбар, хэсэг, бүлэг, хүн, техник, эрэн хайх ажиллагаанд оролцсон эрэлч нохой, ердийн хөсөг (морь, тэмээ, сарлаг г.м)-ийн тоог нөхнө.

ББХАҮМАлба - Байгалийн болон химийн аюулыг үнэлж, мэдээлэх алба
БХБАлба - Барилга, хот байгуулалтын алба
ЗТАлба - Зам, тээврийн алба
УУХҮАлба - Уул уурхай, хүнд үйлдвэрийн алба
ХАНХАлба - Хүн ам, нийгмийн хамгааллын алба
ХХАААлба - Хүнс, хөдөө аж ахуйн алба
ТЭХАлба - Түлш, эрчим хүчний алба
ЭМАлба - Эрүүл мэндийн алба
МХХАлба - Мэдээлэл, харилцаа холбооны алба
МБЦХАлба - Мэргэжлийн болон цацрагийн хяналтын алба
ХЖСАлба - Хэв журам сахиулах алба
САлба - Сурталчилгааны алба

БҮЛЭГ III ХОХИРОЛ, ХЭРЭГЦЭЭ

9. Зарцуулсан зардал

Аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны зардлыг онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дуррын хэсэг, нутгийн захиргааны байгууллага, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, дайчлагдан ажилласан болон олон улсын байгууллага, бусад эх үүсвэрээс гаргасан зардлаар ангилан зардлын задаргааг байгууллага тус бүрээр албажуулан хавсаргана. Хэмжих нэгж нь сая төгрөг байна.

- 1 дүгээр мөрөнд** Зарцуулсан нийт зардал буюу 2,10 дугаар мөрний нийлбэр дүнг нөхнө.
- 2 дугаар мөрөнд** аврах, хор уршгийг арилгах ажиллагааны нийт зардал буюу 3-9 дүгээр мөрөнд бичигдсэн зардлын нийлбэр дүнг нөхнө.
- 3 дугаар мөрөнд** аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд зарцуулсан тээвэр, шатахууны зардлын дүнг нөхнө.
- 4 дүгээр мөрөнд** аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд зарцуулсан хоол, хүнсний зардлын дүнг нөхнө.
- 5 дугаар мөрөнд** аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд зарцуулсан шуудан холбооны зардлын дүнг нөхнө.
- 6 дугаар мөрөнд** аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд оролцсон алба хаагчдын томилолт, урамшууллын зардлын дүнг нөхнө.
- 7 дугаар мөрөнд** аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд зарцуулсан ариутгал, халдваргүйтгэлийн зардлын дүнг нөхнө.
- 8 дугаар мөрөнд** аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд зарцуулсан эм, боох материалын зардлын дүнг нөхнө.
- 9 дүгээр мөрөнд** дээрх 2-8 дугаар мөрөнд тавигдсан зардлаас бусад аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд зарцуулсан зардлыг нөхнө.
- 10 дугаар мөрөнд** сэргээн босгох үйл ажиллагааны нийт зардал буюу 11-19 дүгээр мөрөнд бичигдсэн зардлын нийлбэр дүнг нөхнө.
- 11 дүгээр мөрөнд** сэргээн босгох ажиллагаанд зарцуулсан тээвэр, шатахууны зардлын дүнг нөхнө.
- 12 дугаар мөрөнд** сэргээн босгох ажиллагаанд зарцуулсан хоол, хүнсний зардлын дүнг нөхнө.
- 13 дугаар мөрөнд** сэргээн босгох ажиллагаанд зарцуулсан шуудан холбооны зардлын дүнг нөхнө.
- 14 дүгээр мөрөнд** сэргээн босгох ажиллагаанд оролцсон алба хаагчдын томилолт, урамшууллын зардлын дүнг нөхнө.
- 15 дугаар мөрөнд** сэргээн босгох ажиллагаанд зарцуулсан ариутгал, халдваргүйтгэлийн зардлын дүнг нөхнө.
- 16 дугаар мөрөнд** сэргээн босгох ажиллагаанд зарцуулсан материалын зардлын дүнг нөхнө.

17 дугаар мөрөнд сэргээн босгох ажиллагаанд зарцуулсан бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлын дүнг нөхнө.

18 дугаар мөрөнд сэргээн босгох ажиллагаанд улсын нөөцөөс зарцуулсан хөрөнгийг нөхөн бүрдүүлэх зардлын дүнг нөхнө.

19 дүгээр мөрөнд дээрх 11-18 дугаар мөрөнд тавигдсан зардлаас бусад сэргээн босгох ажиллагаанд зарцуулсан зардлыг бичнэ.

10. Нэрвэгдсэн хүн амын үндсэн үзүүлэлт

Осолд нэрвэгдсэн хүн амыг нийт дүн, хүйс, өгөгдсөн насны бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй, гадаадын иргэн гэсэн үзүүлэлтүүдээр ялгана.

“гадаадын иргэн” гэж Монгол Улсын иргэний харьяалалгүй бөгөөд гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг хэлнэ.

1 дүгээр мөрөнд осолд нэрвэгдсэн хүний тоог нөхнө. Тухайн ослын улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирсон иргэдийг авч үзнэ.

2 дугаар мөрөнд ослын улмаас нас барсан иргэдийн тоог нөхнө. Нас барсан хүний дэлгэрэнгүй бүртгэлийг маягтын дагуу хавсаргана.

3 дугаар мөрөнд эрэн хайх, аврах багийн болон иргэдийн аварсан хүний тоог нөхнө.

4 дүгээр мөрөнд ослын улмаас бэртэж гэмтсэн, хордсон иргэдийн тоог нөхнө.

5 дугаар мөрөнд ослын голомтоос шилжүүлсэн иргэдийн тоог нөхнө.

6 дугаар мөрөнд ослын улмаас төөрсөн, сураггүй болсон иргэдийн тоог нөхнө.

7 дугаар мөрөнд ослын улмаас орон байр, гэргүй болсон иргэдийн тоог нөхнө. Үүнд орон байр, гэр нь цаашид ашиглах боломжгүй болсныг тусгана.

8 дугаар мөрөнд ослын улмаас орон байр, гэр сууцанд хохирол учирсан хэдий ч цаашид ашиглах боломжтой иргэдийн тоог нөхнө.

9 дүгээр мөрөнд ослын улмаас орон байр, гэр сууцанд хохирол учирснаас аюулгүй бүсэд нүүлгэн шилжүүлсэн иргэдийн тоог нөхнө.

11. Нэрвэгдсэн өрх, байгууллагын үндсэн үзүүлэлтүүд

Осолд өртсөн өрх, байгууллагын тоог албан ёсны бүртгэл, тухайн үед байсан, орон байр, гэргүй болсон, орон байр, гэр нь эвдэрсэн зэрэг үзүүлэлтээр ялган нөхнө.

12. Учирсан бодит хохирол

Тухайн осолд өртсөн талбайг “га”-аар, бусад барилга байгууламж, гэр, байр орон сууцыг ширхэгээр хэмжинэ.

Учирсан хохирлын мөнгөн дүнг гамшгийн хор уршгийг арилгах үед хийгдэх нөхцөл байдлын үнэлгээ, хойшлуулшгүй сэргээн босгох үеийн үнэлгээгээр нарийвчлан тогтоож болно.

2-4 дүгээр мөрөнд осолд өртсөн, бохирдсон хөрс, ус, агаарын хэмжээг нөхнө.

6-11 дүгээр мөрөнд тухайн осолд өртөж эвдэрч сүйдсэн болон бохирдсон гэр, байр, орон сууц, тээврийн хэрэгслийг өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

12 дугаар мөрөнд осолд өртөж эвдэрч сүйдсэн нийт барилга, байгууламжийн тоог нөхнө.

13 дугаар мөрөнд осолд өртөж эвдэрч сүйдсэн улсын онц чухал объектын тоог нөхнө.

“улсын онц чухал объект” гэж Монгол Улсын Засгийн газраас тогтоосон улс орны нийгэм, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий үйлдвэр, албан газар, байгууллага, барилга байгууламжийг хэлнэ.

14 дүгээр мөрөнд осолд өртөж эвдэрч сүйдсэн галын онц аюултай объектын тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

15 дугаар мөрөнд осолд өртөж эвдэрч сүйдсэн эмнэлэг, эрүүл мэндийн барилга, байгууламжийн тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө. Үүнд эрүүл мэндийн төв, эмнэлэг, хувийн эмнэлэг зэргийг хамааруулна.

16 дугаар мөрөнд осолд өртөж эвдэрч сүйдсэн боловсролын байгууллагын барилга, байгууламжийн тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө. Үүнд их, дээд сургууль, коллеж ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, зуслан, мэргэжил-сургалт үйлдвэрлэлийн төв, сургалтын төв, хүүхдийн засан хүмүүжүүлэх төв зэргийг хамааруулна.

- 17 дугаар мөрөнд** осолд өртөж эвдэрч сүйдсэн дэд бүтцийн байгууламжийн нийт тоог нөхнө.
- 18 дугаар мөрөнд** осолд өртөж эвдэрч сүйдсэн эрчим хүчний дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд шугам сүлжээ, дамжуулах шугам/сүлжээ, цахилгаан станц, дэд станц болон дахин дамжуулах станцыг хамааруулна.
- 19 дүгээр мөрөнд** осолд өртөж эвдэрч сүйдсэн зам тээврийн дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд хучилттай зам, сайжруулсан зам, гүүр, төмөр зам, төмөр замын өртөө, нисэх буудал зэргийг хамааруулна.
- 20 дугаар мөрөнд** осолд өртөж эвдэрч сүйдсэн мэдээлэл харилцаа холбооны дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд холбооны шугам, харилцаа холбооны тоног төхөөрөмж зэргийг хамааруулна.
- 21 дүгээр мөрөнд** осолд өртөж эвдэрч сүйдсэн усан хангамжийн дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд ус түгээх сүлжээ, ус цэвэрлэх байгууламж, худаг зэргийг хамааруулна.
- 22 дугаар мөрөнд** осолд өртөж эвдэрч сүйдсэн засгийн газрын барилга, байгууламжийн тоог нөхнө.
- 23 дугаар мөрөнд** осолд өртөж эвдэрч сүйдсэн хамгаалах дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд үерээс хамгаалах далан, ус зайлуулах систем, аюулыг хянах, зарлан мэдээлэх дэд бүтэц, нөөцийн агуулах зэргийг хамааруулна.
- 24 дүгээр мөрөнд** осолд өртөж эвдэрч сүйдсэн ногоон дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн зүлэгжүүлсэн талбай, усан сан, оргилуур, хотын ногоон байгууламж зэргийг хамааруулна.
- 25 дугаар мөрөнд** осолд өртөж эвдэрч сүйдсэн түр цугларах байрны тоог нөхнө.
- 26 дугаар мөрөнд** осолд өртөж эвдэрч сүйдсэн хорогдох байрны тоог нөхнө.
- 27 дугаар мөрөнд** ослын улмаас нурангид дарагдсан хот суурин газрын талбайн хэмжээг нөхнө.
- 28 дугаар мөрөнд** 13-27 дугаар мөрөнд бичигдсэнээс бусад осолд өртөж эвдэрч сүйдсэн барилга, байгууламжийн тоог нөхнө.
- 29 дүгээр мөрөнд** ослын улмаас бохирдсон барилга, байгууламжийн нийт тоог нөхнө.
- 30 дугаар мөрөнд** осолд өртөж бохирдсон улсын онц чухал объектын тоог нөхнө. “улсын онц чухал объект” гэж Монгол Улсын Засгийн газраас тогтоосон улс орны нийгэм, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий үйлдвэр, албан газар, байгууллага, барилга байгууламжийг хэлнэ.
- 31 дүгээр мөрөнд** осолд өртөж бохирдсон галын онц аюултай объектын тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө.
- 32 дугаар мөрөнд** осолд өртөж бохирдсон эмнэлэг, эрүүл мэндийн барилга, байгууламжийн тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө. Үүнд эрүүл мэндийн төв, эмнэлэг, хувийн эмнэлэг зэргийг хамааруулна.
- 33 дугаар мөрөнд** осолд өртөж бохирдсон боловсролын байгууллагын барилга, байгууламжийн тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө. Үүнд их, дээд сургууль, коллеж ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, зуслан, мэргэжил-сургалт үйлдвэрлэлийн төв, сургалтын төв, хүүхдийн засан хүмүүжүүлэх төв зэргийг хамааруулна.
- 34 дүгээр мөрөнд** осолд өртөж бохирдсон дэд бүтцийн байгууламжийн нийт тоог нөхнө.
- 35 дугаар мөрөнд** осолд өртөж бохирдсон эрчим хүчний дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд шугам сүлжээ, дамжуулах шугам/сүлжээ, цахилгаан станц, дэд станц болон дахин дамжуулах станцыг хамааруулна.
- 36 дугаар мөрөнд** осолд өртөж бохирдсон зам тээврийн дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд хучилттай зам, сайжруулсан зам, гүүр, төмөр зам, төмөр замын өртөө, нисэх буудал зэргийг хамааруулна.
- 37 дугаар мөрөнд** осолд өртөж бохирдсон мэдээлэл харилцаа холбооны дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд холбооны шугам, харилцаа холбооны тоног төхөөрөмж зэргийг хамааруулна.
- 38 дугаар мөрөнд** осолд өртөж бохирдсон усан хангамжийн дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд ус түгээх сүлжээ, ус цэвэрлэх байгууламж, худаг зэргийг хамааруулна.

39 дүгээр мөрөнд осолд өртөж бохирдсон засгийн газрын барилга, байгууламжийн тоог нөхнө.

40 дүгээр мөрөнд осолд өртөж бохирдсон хамгаалах дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд үерээс хамгаалах далан, ус зайлуулах систем, аюулыг хянах, зарлан мэдээлэх дэд бүтэц, нөөцийн агуулах зэргийг хамааруулна.

41 дүгээр мөрөнд осолд өртөж бохирдсон ногоон дэд бүтэц, байгууламжийн тоог нөхнө. Үүнд цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн зүлэгжүүлсэн талбай, усан сан, оргилуур, хотын ногоон байгууламж зэргийг хамааруулна.

42 дугаар мөрөнд осолд өртөж бохирдсон түр цугларах байрны тоог нөхнө.

43 дугаар мөрөнд осолд өртөж бохирдсон хорогдох байрны тоог нөхнө.

44 дүгээр мөрөнд 30-43 дугаар мөрөнд бичигдсэнээс бусад осолд өртөж бохирдсон барилга, байгууламжийн тоог нөхнө.

45 дугаар мөрөнд осолд өртөж хорогдсон малын нийт тоог нөхнө.

46 дугаар мөрөнд осолд өртөж хорогдсон бод малын тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

47 дугаар мөрөнд осолд өртөж хорогдсон бог малын тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

48 дугаар мөрөнд осолд өртөж хорогдсон тэжээвэр амьтны тоог өмчийн хэлбэрийн хамт нөхнө.

49 дүгээр мөрөнд осолд өртөж хорогдсон ан амьтны тоог нөхнө.

Тухайн осол цаашид тархан дэлгэрэх аюултай ТИЙМ гэснийг сонгосон тохиолдолд Хэрэгцээний тойм хүснэгтийг бөглөнө.

13. Аварсан эд хөрөнгө

Аюулт үзэгдэл, ослоос авран хамгаалсан эд хөрөнгийг үзүүлэлтийн дагуу тоо ширхэг, өмчийн хэлбэр, аварсан хөрөнгийн дүнгийн хамт нөхнө.

14. Хэрэгцээний тойм

Хэрэгцээний тойм хүснэгтэд осолд нэрвэгдсэн хүн амын анхдагч хэрэгцээг хангахад шаардлагатай тусламж, үйлчилгээний мэдээлэл, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд шаардагдах хүч хэрэгсэл, зардлын тооцоо, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц, санхүү, техникийн мэдээллийг бөглөнө.

БҮЛЭГ IV ГАМШГИЙН ТҮВШИН, ЗЭРЭГЛЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг ашиглан гаргасан мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн шатны онцгой комисс гамшгийн зэрэглэлийг тогтооно.

/ЗГ-ын 2018 оны 327 дугаар тогтоол "Гамшгийн зэрэглэл тогтоох журам"-ын 3.2-т зааснаар/

15. Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт

Тухайн ослын үзүүлэлтийг үр дүнгээр мөрөнд нөхөж шалгуурыг давсан эсэхийг үнэлнэ.

16. Гамшгийг тодорхойлох

Тухайн гамшгийн төрөлд хамаарах нийт шалгуур үзүүлэлтийн 50 хувь нь бүрдсэн байвал гамшиг болсонд тооцно.